



Захирлын 2017 оны 05 дугаар сарын 29-ны  
өдрийн дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

УХДСЭТ2 9184359

МУИС-ИЙН ХАРЬЯА БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ  
АХЛАХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей ахлах сургуулийн байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай 10 дугаар ангид нийслэл хот болон хөдөө орон нутгаас суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг баримтална.
2. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
3. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр хүсэлт гаргасан сурагчийг "бүртгүүлэгч", зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг "элсэлтийн комисс", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг "комиссын гишүүн" гэнэ.
4. Байгаль-Эх лицей ахлах сургуульд суралцагч элсүүлэх ажлыг МУИС-ийн захирлын тушаалаар томилсон комисс зохион байгуулна.
5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://www.num.edu.mn/> <http://eecbehs.num.edu.mn/> цахим хуудсанд байрлуулна.
7. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан элсэлтийн комисс шийдвэрлэнэ.
8. Тус сургуульд элсэхийг хүссэн, суурь боловсролын /9 дүгээр анги төгссөн/ гэрчилгээтэй суралцагчдыг бүртгэнэ.
9. Математик, физик, хими, биологи, газарзүй, мэдээлэл зүйн улсын төрөлжсөн олимпиадад оролцсон суралцагчдыг тус сургуулийн тухайн чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалттай 10 дугаар ангид шалгалтгүй элсүүлж, гүнзгийрүүлсэн сургалтын төлбөрийг зохих хувиар хөнгөлнө. Байгаль-Эх лицей ахлах сургуулийн нэрэмжит олимпиадад амжилттай оролцсон суралцагчдыг шалгалтгүй элсүүлж, эрхийн бичигт заасны дагуу төлбөрийг зохих хувиар хөнгөлнө.
10. Нийт бүртгүүлэгчдээс суурь шалгалт болох математик, англи хэлний шалгалтыг авна. Суурь шалгалтын /40:10/ оноогоор жагсааж, зохих шаардлагыг хангасан суралцагч гүнзгийрүүлэн судлах хичээлийн шалгалт ёгнө.

11. Суурь шалгалтын оноогоор эхний 50-д багтсан суралцагч математикийн бүлэгт элсэх шалгалт өгөх эрхтэй.
12. Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай бүлэгт элсэх суралцагчдын шалгалтыг уламжлалт аргаар /бодолт/, физик, хими, биологи, газар зүй, мэдээлэл зүйн гүнзгийрүүлсэн сургалттай бүлэгт элсэх суралцагчдын шалгалтыг тестээр авна.
13. Суралцагчдыг хоёр шалгалтын нийлбэр /40:10:50/ оноогоор жагсааж, гүнзгийрүүлэн судлах чиглэлийн бүлэг тус бүрээр зохих хяналтын тоонд багтааж элсүүлнэ. Оноо тэнцсэн тохиолдолд математикийн болон гүнзгийрүүлэн судлах хичээлийн шалгалтын оноогоор эрэмбэлнэ.
14. Тухайн элсэгчийн сонгосон бүлгээс өөр бүлэгт шилжүүлэн элсүүлэхгүй ба элсэлтийн эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
15. Элсэлтийн шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сэдэв боловсруулах, шалгалтын хугацаа ба үнэлгээний шалгуур тогтоох, нууцлал хадгалах зэрэг асуудлыг элсэлтийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, комиссын гишүүд хариуцна.
16. Элсэх зохих болзол хангаж, хяналтын тоонд багтсан бүргүүлэгчдийг заасан хугацаанд бүртгэж, элсэх эрх олгоно. Бүртгүүлэгч элсэх эрх авахдаа дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- төрсний гэрчилгээний хуулбар
  - суурь боловсролын гэрчилгээ
  - хувийн хэрэг /шилжүүлсэн байх/
  - төлбөр төлсөн баримт
17. Зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй суралцагчийг тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэн, дараа өдрийн 10:00 цагаар тасалбар болгон онооны дарааллаар дараагийн шалгуулагчид элсэх эрхийг шилжүүлнэ.